



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01

Майхан

Цалин шинэчлэн тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1, 4, 5 дугаар хавсралт, 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2, 9 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын цалинг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.
2. Албан хаагчдад хавсралтын дагуу цалинг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны “Цалин шинэчлэн тогтоох тухай” А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тоосугай.



Г.БАТ-ЭРДЭНЭ

1069000000

My Doc/A4 tushaal/ doc

Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн  
Алс дугаар тушаалын хавсралт



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ШИНЭЧЛЭН ТООЦСОН ЦАЛИН

№	Овог нэр	Албан тушаал	Нийт ажилласан жил	Үүнээс төрд	Зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдлүүд хувиар							Тооцсон бугд цалин	
							Удаан жил	Зөвгөд дэв	Ур чадвар	Мэргэшлийн зэрэг	Ажил хавсарсны	ҮСХороо, Сангийн сайд 2012, 1/48, 88			
1	М.Отгонбат	Санхүү албаны дарга	23	14	T3-5-5	791532	10	22				20			1203129
2	Г.Буянтогтох	Хууль, эрх зүйн мэргэжилтэн	16	12	T3-3-5	717662	10	16				20			1047787
3	Ч.Баярсайхан	Хөдөө, аж ахуйн тасгийн дарга	15	11	T3-3-5	717662	10	16							904254
4	Г.Батзаяа	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	4	4	T3-3-4	685168									685168
5	Д.Энхтуяа	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	5	5	T3-3-2	619078		10					20		804801
6	Т.Цэндмаа	Архив, бичиг хэргийн эрхлэгч	2	1	TY-5-2	567152			10						623867
7	Б.Мөнхзул	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	3	2	TY-4-1	524696									524696
8	Э.Эрдэнэчимэг	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1	1	T3-3-1	585493									585493
9	Я.Дагмидмаа	Нягтлан бодогч	14	8	TY-8-4	757161	5		25						984309
10	Г.Оюун	Нярав-үйлчлэгч	6	4	TY-4-3	538350			25						672938
11	М.Мөнх-Од	Жолооч	5	5	TY-3-2	510172			10			40			765258

-000-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А02

Майхан

Ахмадын сан байгуулах тухай

Монгол Улсын Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын цалингийн сангийн 0.1 хувиар Ахмадын сан байгуулсугай.
2. Ахмадын сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу зарцуулж, тайлганахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д даалгасугай.

ДАРГА



Г.БАТ-ЭРДЭНЭ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/03


Майхан

Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах,  
ажиллах журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Сумын Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын нийт албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээ сахин биелүүлэх талаар жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг нэг мөр хэвшүүлэн, "Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-ыг мөрдлөг болгон ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга (Г.Буянтогтох)-д даалгасугай.

ДАРГА  Г.БАТ-ЭРДЭНЭ  
ИДА 0013

1000000000

Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн  
№03 дугаар тушаалын хавсралт




## ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Г.Буянтогтох (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Энхтуяа (Төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүн: Ц.Оюун-Эрдэнэ (Улсын бүртгэгч)

Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын .....-ны өдрийн  
4/03 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг сахиулах, мөрдүүлэх чиг үүрэгтэй ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн зорилго нь төрийн албан хаагчийн баримтлах "Ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчдын мэргэжлийн ёс зүйг мөрдөж, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, аливаа зөрчил, гажуудлаас сэргийлэхэд оршино.

1.3. Байгууллагын Ёс зүйн зөвлөл нь нийт ажиллагсдын саналаар сонгогдсон, 3 жилийн хугацаагаар томилогддог, ажиллагсдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт /тогтоол/ гаргах эрх бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус зөвлөл байна.

1.4. Зөвлөлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хүрээнд явагдана.

### Хоёр. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн чиг үүрэг

2.1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг жил бүр төлөвлөн зохион байгуулах, хамтран ажиллах.

2.2. Гомдол, мэдээлэлд холбогдох төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч тэдгээрийг удирдах эрх бүхий албан тушаалтан, гомдол мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг гаргуулан авах, нөхцөл байдлын үнэлгээг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу хэрэгжүүлэх.

2.3. Гомдол, мэдээллийн нууцлалыг хадгалах, шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахуулахаар холбогдох байгууллагад хандах.

2.4. Зөвлөлийн дарга хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол харьяаллын гомдол, мэдээллийг хүлээж авснаас хойш хуанлын 14 хоногийн дотор зөвлөлийн гишүүдэд гомдол мэдээллийг тухай бүр хуваарилах ба гомдол мэдээллийг шалгасан, мэдээлэл цуглуулсан гишүүн зөвлөлийн хуралдаанд танилцуулга бэлтгэж оруулна. Гомдол мэдээллийг шалгах үүрэг хүлээсэн зөвлөлийн гишүүн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 5.2-т заасан шаардлагын дагуу гомдлыг шалгах.

2.5. Гомдол, мэдээллийг шалгах хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн дарга байгууллагын даргад танилцуулан хугацааг сунгах эсэхийг шийдвэрлүүлэх.

2.6. Зөвлөлийн хуралдаанд шаардлагатай тохиолдолд зөрчил гаргагч болон гомдол мэдээлэлд холбогдсон албан хаагчдыг оролцуулж, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар асуулт асууж, хариулт авах, нэмэлт тайлбар, санал гаргах боломжийг олгох.

2.7. Гомдол, мэдээлэл шалгасан тухай дүнг гишүүдийн ердийн олонхийн ирцтэй хуралдан хэлэлцэж, үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасан хариуцлагыг хүлээлгэх тухай тогтоол гаргах.

2.8. Зөвлөл нь гомдол, мэдээллээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр, түүнчлэн өөрийн санаачлагаар болон байгууллагын нэгжийн даргаас ирсэн санал гомдол, эсхүл дотоод хяналт, шалгалт хариуцсан нэгжийн зөвлөмж, мэдээллийг хүлээн авч, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг явуулах.

### **Гурав. Зөвлөлийн шийдвэр, хүлээлгэх хариуцлага**

3.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйгээр тогтоогдсон ёс зүй зөрчилд зөрчлийн шинж байдлаас хамааран зөвлөлийн тогтоолоор хариуцлага хүлээлгэнэ.

3.2. Ёс зүйн зөрчлийн хариуцлага нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

3.2.1. Уучлал гуйхыг үүрэг болгох. Үүнд төрийн албан хаагчийн харилцаа хандлага бусад хэлбэрээс гарсан үйлдэл, хор уршгийг өөрөө биечлэн арилгах, хугацаатай үүрэг даалгавар өгч өөрийн алдаа дутагдалд дүн шинжилгээ хийх боломжийг олгоно.

3.2.2. Сануулах. Үүнд зөрчлийг анх удаа гаргасан нөхцөл байдалд үнэлгээ хийж, нэг удаа сануулах, 2 ба түүнээс дээш удаа дараа ёс зүйн зөрчил гаргавал байгууллагын даргад танилцуулж, холбогдох хууль тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулах тухай санал хүргүүлнэ.

3.3. Төрийн албан хаагч ёс зүйн зөрчлөө хүлээн зөвшөөрч сайн дураар ажлаас чөлөөлөгдөх хүсэлт ирүүлэх, мөн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, байгууллагын дарга арга хэмжээ тооцох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.4. Гомдол мэдээлэл гаргагч болон гомдол мэдээлэлд холбогдсон албан хаагчийн хүсэлтээр энэхүү журмын 3.3-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Ёс зүйн зөвлөлийн санал, дүгнэлтийг /тогтоол/ хянаж үзээд дараах үндэслэлээр дахин шалгуулахаар Ёс зүйн зөвлөлд гомдлыг буцаах шийдвэр гаргаж болно.

3.4.1. Ёс зүйн зөрчил гаргасан нотолгоо, баримт бичгийн бүрдэл хангагдаагүй

3.4.2. Хэт нэг талын мэдээллийг барьсан, ашиг сонирхлын зөрчил тогтоогдсон

3.4.3. Бусад

### **Дөрөв. Ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх**

4.1. Байгууллагын Ёс зүйн зөвлөл нь төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, дүн шинжилгээ хийж,

урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр зохион байгуулна. Мөн жилийн эцсийн тайланг өссөн дүнгээр гарган аймгийн Төрийн албаны салбар зөвлөл болон байгууллагын даргад төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт хүргүүлнэ.

4.2. Ёс зүйн зөвлөлийн тогтоолыг байгууллагын даргад болон зөрчил гаргасан албан хаагчид танилцуулах бөгөөд тогтоолын хувийг төрийн албан хаагчийн хувийн хэрэгт хавсарган, байгууллагын дотоод сүлжээгээр байршуулан бусад албан хаагчдад мэдэгдэнэ.

4.3. Ёс зүйн зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэж, харилцан ойлголцох, төрийн албан хаагчийн харилцаа хандлагыг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, ил тод байдлыг сахин ажиллах чиглэлээр байгууллагын удирдлагад санал хүргүүлнэ.

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/04

Майхан

Байгууллагын эцэг эхийн зөвлөл  
байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 16.4.2 дахь заалтууд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай" 03дугаар тогтоол, Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын эцэг эхийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Ч.Баярсайхан (Хөдөө, аж ахуйн тасгийн дарга)

Д.Чанцал (4 дүгээр багийн Засаг дарга)

Т.Ишдорж (Татварын байцаагч)

Б.Энхтуул (Нийгмийн даатгалын байцаагч)

2. Журамд заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулан, дүн мэдээг хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн мэргэжилтэн (Г.Буянтогтох)-д даалгасугай.

ДАРГА  Г.БАТ-ЭРДЭНЭ

1060000000

My Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/05

Сант сум

Эд хөрөнгийн тооллого явуулах  
ажлын хэсэг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2, 72.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого болох гэж байгаатай холбогдуулан байгууллагын эд хөрөнгө, өмчийн тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Отгонбат (Санхүү албаны дарга)

Гишүүд: Ч.Баярсайхан (Хөдөө, аж ахуйн тасгийн дарга)

Ч.Баярбат (Газрын даамал)

Ц.Оюун-Эрдэнэ (Улсын бүртгэгч)

О.Алтангэрэл (2 дугаар багийн Засаг дарга)

2.Эд хөрөнгө, өмчийн тооллогыг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 13-ны өдөр хүртэл явуулсугай.

3.Байгууллагын эд хөрөнгийг нүд үзэн тоолж, тэмдэглэл хөтлөн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Отгонбат)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Г.БАТ-ЭРДЭНЭ

1060000000

My Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1/06

Сант сум

Өмч хамгаалах байнгын зөвлөл шинэчлэн  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын "Өмч хамгаалах зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Д.Энхтуяа (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Г.Оюун (Нярав үйлчлэгч)

Ч.Баярсайхан (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Т.Цэндмаа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Ц.Оюун-Эрдэнэ (Улсын бүртгэгч)

2.Өмч хамгаалах зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөөг батлуулж, байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж, зохих журам дүрмийн дагуу удирдлага зохион байгуулалтаар ханган, үр дүнг хагас бүтэн жилээр танилцуулахыг Зөвлөлийн дарга (Д.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.БАТ-ЭРДЭНЭ

ИВА 0013

106000001

My Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/07

Сант сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл болон цалингийн доод хэмжээг хавсралтад зааснаар шинэчлэн тогтоосугай.

2.Дээрх шинэчлэн тогтоосон цалинг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн захиргааны албан хаагч, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн үйлчилгээний албан хаагч нарт тооцож олгохыг нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Цалин шинэчлэн тогтоох тухай” А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тоосугай.

ДАРГА



Г.БАТ-ЭРДЭНЭ

106000001

D:My.Doc/A4 tushaal/ doc

Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн  
107 дугаар тушаалын хавсралт

ИЛА 0013

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН  
АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИНГИЙН ШАТЛАЛ

д/д	Овог нэр	Шатлал	Үндсэн цалин
1	М.Отгонбат	ТЗ-7-5	924456
2	Г.Буянтогтох	ТЗ-4-5	756002
3	Ч.Баярсайхан	ТЗ-4-5	756002
4	Г.Батзаяа	ТЗ-4-4	721343
5	Д.Энхтуяа	ТЗ-6-2	731527
6	Э.Эрдэнэчимэг	ТЗ-4-1	615022
7	Я.Дагмидмаа	ТҮ-8-5	797676
8	Т.Цэндмаа	ТҮ-5-5	635776
9	Г.Оюун	ТҮ-4-5	590937
10	М.Мөнх-Од	ТҮ-3-5	569585

-ооо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/08

Сант сум

Үр дүнгийн урамшуулал олгох тухай

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2, 2 дугаар зүйлийн 2.2, 2.4, 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийн үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.14.1, 4.14.2, байгууллагын даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн дотоод журмын 6.2.6, 6.3.2, 6.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хагас жилийн ажлын үр дүнгээр маш сайн, сайн үнэлэгдсэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад олгох үр дүнгийн урамшууллыг хавсралтаар баталсугай.

2. Хагас жилийн ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас олгохыг сумын Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.




ДАРГА

Г.БАТ-ЭРДЭНЭ

10600000010

My Doc/A4 tushaal/ doc

Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
2022 оны 06 дугаар сарын 24 ны өдрийн  
118 дугаар тушаалын хавсралт



ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ

д/д	Овог нэр	Урамшуулал олгох хувь
1	Г.Буянтогтох	80
2	М.Отгонбат	80
3	Ч.Баярсайхан	60
4	Я.Дагмидмаа	80
5	Г.Батзаяа	60
6	Д.Энхтуяа	80
7	Т.Цэндмаа	80
8	Г.Оюун	80
9	Э.Эрдэнэчимэг	60
10	М.Мөнх-Од	40

-ооо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/09

Сант сум

Байгууллагын баримт нягтлан шалгах комисс  
шинэчлэн байгуулах тухай

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь

1. Байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Засаг даргын Тамгын газрын дарга  
Гишүүд: Хууль, эрх зүйн мэргэжилтэн  
Хөдөө, аж ахуйн тасгийн мэргэжилтэн  
Нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга: Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Баримт нягтлан шалгах комиссын дүрмийг хавсралтаар баталж, энэ дүрмийг тушаал гарсан өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Байгууллагын архивын ажлын үндсэн зааврыг мөрдөж ажиллахыг Комиссын даргад үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх, дүрмийг батлах тухай" А/03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.БАТ-ЭРДЭНЭ



106000001

D:My.Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/10

Сант сум

Хоолын мөнгө олгох тухай

Байгууллагын даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн дотоод журмын 6.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтан болон албан хаагч нарт дотоод журамд заасны дагуу хоолны мөнгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх хоолны мөнгийг тогтоосон хувь хэмжээгээр цалингийн санд багтаан олгохыг Нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.




ДАРГА

Г.БАТ-ЭРДЭНЭ

106000001

D:My.Doc/A4 tushaal/ doc

Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
2022 оны 11 дугаар сарын 22 ны өдрийн  
110 дугаар тушаалын хавсралт



**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН  
АЛБАН ХААГЧДАД ОЛГОХ ХООЛНЫ МӨНГӨ**

№	Овог	Нэр	Ажиллавал зохих өдөр	Ажилласан	Хоолны мөнгө	Олговол зохих дүн
1	Батбаяр	Адъяатогтох	226	206	3000	618000
2	Түндэв	Цэндмаа	226	211	3000	633000
3	Эрдэнэочир	Эрдэнэчимэг	226	211	3000	633000
4	Гомбодорж	Оюун	226	206	3000	618000
5	Даваасүрэн	Энхтуяа	226	198	3000	594000
6	Ганбаатар	Батзаяа	226	211	3000	633000
7	Галсандаш	Буянтогтох	226	204	3000	612000
8	Чулуунбат	Баярсайхан	226	206	3000	618000
9	Явсрайсүрэн	Догмидмаа	226	205	3000	615000
10	Мөнхнасан	Отгонбат	226	205	3000	615000
Нийт			2260	2063	3000	6189000



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/11

Сант сум

Эд хөрөнгийн тооллого явуулах  
ажлын хэсэг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2, 72.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 12-ний дотор явуулсугай.

2.Эд хөрөнгийн тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бат-Эрдэнэ (Цаг уурын ажилтан)

Гишүүд:

Б.Энхтуул (Нийгмийн даатгалын улсын байцаагч)

Г.Батзаяа (Байгаль орчны хяналтын улсын  
байцаагч)

3.Эд хөрөнгийн тооллого явуулах ажлын хэсэг нь байгууллагын өмч хамгаалах зөвлөлтэй хамтран ажиллаж тооллогын ажилд хяналт тавьж, дүн мэдээг нэгтгэж, зохион байгуулж, баталсан маягтын дагуу бүрдүүлж тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА

Г.БАТ-ЭРДЭНЭ

106000002

D:My.Doc/A4 tushaal/ doc



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/12

Сант сум

Үр дүнгийн урамшуулал болон хоолны  
мөнгө олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2, 2 дугаар зүйлийн 2.2, 2.4, 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийн үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.14.1, 4.14.2, байгууллагын даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн дотоод журмын 6.2.6, 6.3.2, 6.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жилийн эцсийн ажлын үр дүнгээр маш сайн, сайн үнэлэгдсэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад олгох үр дүнгийн урамшууллыг нэгдүгээр хавсралтаар, албан хаагчдийн хоолны мөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Жилийн эцсийн ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал болон хоолны мөнгийг тогтоосон хувь хэмжээгээр цалингийн санд багтаан олгохыг сумын Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Г.БАТ-ЭРДЭНЭ


Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 4 дүгээр  
тушаалын нэгдүгээр хавсралт



Үр дүнгийн урамшуулал

Д/д	Овог нэр	Урамшуулал олгох хувь
1	М.Отгонбат	80
2	Г.Буянтогтох	80
3	Ч.Баярсайхан	70
4	Я.Дагмидмаа	80
5	Г.Батзаяа	80
6	Д.Энхтуяа	80
7	Т.Цэндмаа	80
8	Г.Оюун	80
9	Э.Эрдэнэчимэг	70
10	Д.Төмөрхуяг	30

Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын  
оны ...<sup>12</sup> дугаар сарын ...<sup>15</sup>-ны өдрийн ...<sup>12</sup> дүгээр  
тушаалын хоёрдугаар хавсралт



Хоолны мөнгө

№	Овог, нэр	Хоног	Нэг хоногт ноогдох хоолны үнэ	Нийт
1	Б.Адъяатогтох	21	3000	63000
2	О.Ганпүрэв	21	3000	63000
3	Г.Бат-Эрдэнэ	21	3000	63000
4	М.Отгонбат	18	3000	54000
5	Г.Буянтогтох	21	3000	63000
6	Ч.Баярсайхан	21	3000	63000
7	Д.Энхтуяа	21	3000	63000
8	Г.Батзаяа	21	3000	63000
9	Я.Дагмидмаа	21	3000	63000
10	Э.Эрдэнэчимэг	21	3000	63000
11	Т.Цэндмаа	21	3000	63000
12	Г.Оюун	21	3000	63000
13	Д.Төмөрхуяг	38	3000	114000
14	Д.Батбаяр	19	3000	57000
15	О.Алтангэрэл	19	3000	57000
16	С.Жаргалсайхан	19	3000	57000
17	Д.Чанцал	19	3000	57000
18	Ц.Энхболд	19	3000	57000
<b>Нийт:</b>				<b>1146000</b>



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/Б

Сант сум

Урамшуулал олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх заалт, Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 7/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Ганбаатрын Батзаяад 2,000.0 (хоёр сая) төгрөгний мөнгөн урамшуулал олгосугай.

2. Дээрх урамшууллыг сумын Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.



Г.БАТ-ЭРДЭНЭ